

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ 2014 ОНД ЯВУУЛАХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2014-11-15

Алтай хот

№	Төлөвлөсөн зорилт арга хэмжээ	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн Төсөв / мянган төгрөг /
<b>Нэг.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловруулан, батлуулах</b>				
1.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	Хууль зүйн хэлтэс, Ногоон шугуйт төгөл ТББ	02 дугаар сарын 28-ны дотор	Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд иргэд олон нийтийг оролцуулан төлөвлөгөөний төслийг танилцуулан харилцан санал солилцож, төлөвлөгөөний төсөлд иргэний нийгмийн байгууллагын зүгээс гаргасан санал санаачлагыг тусган төлөвлөгөөг батлуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлээ. Хэрэгжилт 100 хувь
1.2	Батлагдсан төлөвлөгөөг иргэдэд танилцуулах арга хэмжээ	Хууль зүйн хэлтэс, Ногоон шугуйт төгөл ТББ, Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага	02 дугаар сарын 25-ны дотор	Аймгийн Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг Ногоон шугуйт төгөл нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагатай хамтран боловсруулж, аймгийн засаг даргын 2014 оны 63 дугаар дугаар захирамжаар батлуулан сум, агентлагуудад хүргүүлж, Энэхүү төлөвлөгөөг Цээл, Шарга, Баян-Уул сумдад сурталчлан, орон нутгийн сонин болон Их Алтайн мэдээ сонины 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 14 дүгээр дугаарт нийтлүүлэн иргэдэд сурталчлах ажлыг зохион байгууллаа. Хэрэгжилт 100 хувь
1.3	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналтыг хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	Нутгийн захиргааны байгууллагууд Хууль зүйн хэлтэс,	11 сарын 15-ны дотор	Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагналтыг хугацаанд нь гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Хэрэгжилт 100 хувь
1.4	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд иргэдээс үнэлгээ авч, хэлэлцсэн дүнг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгоход ашигласан байх	ТЗУХэлтэс, Хууль зүйн хэлтэс		Аймгийн авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар болон Авлигын эсрэг төлөвлөгөөний 2014 оны төлөвлөгөөний төслийг танилцуулах ажлыг Ногоон шугуйт төгөл НҮТББ-тай хамтран 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон төрийн албан хаагчдад танилцуулан төлөвлөгөөнд тусгах ажлын талаар саналыг авч ажиллалаа. Ногоон шугуйт төгөл нийгэмд үйлчлэдэг төрийн бус байгууллагатай хамтран Шарга, Цээл, Баян-Уул сумын иргэд олон нийтэд мэдээлэл хийж хэлэлцүүлэг зохион байгуулан 171 иргэдээс санал авч төсөл хэрэгжүүлж буй төрийн бус байгууллагаас 2014 оны төлөвлөгөөнд нэмж

				тусгах саналуудыг авч төлөвлөгөөнд тусгаж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Хэрэгжилт 100 хувь
Хоёр: Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх.				
2.5	Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчид авлигаас ангид байх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах арга хэмжээ өдөрлөгийг зохион байгуулна үүнд: Баян-Уул, Цээл, Шарга,	Хууль зүйн хэлтэс, Нутгийн захиргааны байгууллагууд, Ногоон шугуйт төгөл ТББ, Мерси-Кор ОУБ,	3, 10 дугаар сард	<p>Цээл, Шарга, Баян-Уул сумдад 2014 оны 02 сарын 26-наас 03 сарын 01-ны хүртэл хугацаанд Мерси-Кор олон улсын байгууллагын идэвхжүүлэгч Г.Мөнх-Эрдэнэ, аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн П.Бат-Очир, Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн Д.Сандагдорж, “Ногоон шугуйт төгөл” НҮТББ-ын ахлагч Ж.Ганбат гишүүн Н.Болдбаатар нар удирдамжийн дагуу ажиллалаа. Уг удирдамжид заасны дагуу аяны нээлтийг дээрх сумдад хийж, сумдын хэмжээнд санхүү төсөв, сум хөгжүүлэх сан, худалдан авах үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг хэрхэн хангаж мэдээлэл ямар хугацаанд иргэдэд ямар хэлбэрээр хүрч байгаатай танилцаж, иргэд олон нийтийн санал хүсэлтийг сонсч 191 хүнээс эдгээр асуудлын хэрэгжилттэй холбогдуулан санал асуулга авч дүгнэлт хийлээ.</p> <p>Мөн тухайн сумдад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, аймгийн Засаг даргын 2014 оны А/62 дугаар захирамжаар батлагдсан Мэдээллийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний захирамж болон “Ил тод мэдээлэл” уралдааны удирдамж, Үндсэн хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар баталгаажсан иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг уулзалт хэлэлцүүлэгт оролцсон иргэдэд ойлгуулах, төр түүний байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй энгийн ойлгомжтой байдлаар хүргэхэд төрийн байгууллагуудын үүрэг түүнийг хэрхэн хангаж ажиллах талаар мэдээлэл зөвлөмжийг өгч ажиллалаа. Уулзалтад Баян-Уул сумд 46, Шарга сумд 53, Цээл сумд 57, Есөнбулаг сумд 35 нийт 191 хүн оролцлоо.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
2.6	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулж, “Хууль дүрэм бодит амьдралд 2 аян”-ы дагуу гаргасан ажлын төлөвлөгөөний дагуу мэдээллийн ил тод байдлыг хангуулах	АИТХ, ХЗХ,	Жилийн турш	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т заасны дагуу авлигатай тэмцэх зорилго бүхий орон нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлын хүрээнд Хууль дүрэм бодит амьдралд 2 аяныг Мерси –кор ОУ-ын байгууллагын аймаг дахь салбартай хамтран удирдамж, ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа.

				Мерси Кор ОУБ-ын хэрэгжүүлж буй “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөө идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн “Залуучуудын Холбоо” НҮТББ “Шилэн дуран” төсөлтэй, Говь-Алтай аймгийн “Ногоон Шугуйт төгөл” НҮТББ “Оролцоог хангасан авлигын эсрэг төлөвлөгөө” төсөлтэй хамтран ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
2.7	Төрийн байгууллагын шийдвэр боловсруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах журам, Мэдээлэлийн ил тод байдлыг хангах талаар аймгийн Засаг даргын захирамжийг гарган батлуулж мөрдүүлнэ.	ТЗУХ, Хууль зүйн хэлтэс	2 дугаар сард	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Үндсэн хууль болон мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар баталгаажсан иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг хангуулж, төр түүний байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй энгийн ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын 2014 оны А/62 дугаар захирамжийг батлан хууль зүйн хэлтсийн даргын 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 5/214 дүгээр албан бичгээр сум, агентлагийн дарга нар т хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Хэрэгжилт 90 хувь
2.8	Аймгийн цахим хуудсанд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах цонх ажиллуулах	Хууль зүйн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс	03 сарын 01-ны дотор	Аймгийн цахим хуудсанд цонх хийж чадаагүй бөгөөд Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл авах мэдээллийг оруулж, аймгийн ЗДТГазар ямар зөрчлийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авах талаар танилцуулгыг аймгийн вэб сайтанд оруулж өглөө. Тус онд авлига, ашиг сонирхлын талаар ойн хандив мөнгөтэй холбоотой Тайшир сумын Засаг даргад холбогдох гомдол бичгээр ирсэнийг Хууль зүйн хэлтсийн даргын 2014 оны ..... тоот албан бичгээр аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шалгуулах хүсэлтийг хүргүүлсэн мөн утсаар ирсэн иргэний мэдээллийн дагуу холбогдох албан тушаалтны дээд шатны албан тушаалтанд хууль тайлбарласан хууль зүйн хэлтсийн даргын 2014 оны 5/1491 дүгээр албан бичгийг хүргүүлж ажиллалаа. Хэрэгжилт 90 хувь
2.9	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах ажлыг төрийн бүх байгууллагууд зохион байгуулж ажиллана. Үүнд: Залуучуудтай”Авлигагүй ирээдүй” сэдэвт уулзалт ярилцлага зохион байгуулах. Мэдээллийн самбар, цахим хуудас, телевизийн нэвтрүүлэг, сонсгол, өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал зэрэг орно. Зохион байгуулсан үйл ажиллагааны талаар холбогдох баримтууд буюу оролцогчдын бүртгэл, фото зураг, зохион	Аймгийн Удирдлагууд, Төрийн байгууллагын удирдлагууд, сумдын ЗДТГ, ХЗХ	Жилийн турш	Мерси-Кор ОУБ, аймгийн Залуучуудын холбоо нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран “Мэдээлэлтэй иргэд оролцоотой” сургалт хэлэлцүүлгийг 05 дугаар сарын 09-ний өдөр аймгийн төрийн байгууллага, хэлтэс агентлагуудын удирдлага, сургалт мэдээлэл хариуцсан 24 ажилтан албан хаагчдыг оролцуулан зохион байгууллаа. Энэ удаагийн сургалт хэлэлцүүлгийг оролцооны аргыг түлхүү хэрэглэн аль болох цаашид хэрхэн ажиллах санал авахад чиглүүлээ.

	байгуулсан арга хэмжээний хөтөлбөр, тайлан гэх мэт мэдээллийг баримтжуулсан байна.			<p>Сургалт 5 цаг үргэлжлэн Маргад-Эрдэнэ Хуульзүйн хэлтсийн дарга Сургалтын нээлт, хөтөлбөр танилцуулсан, Д. Баттайван Хуульзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Б. Даваацэрэн Аймгийн Залуучуудын холбооны нарийн бичиг Сургалтын өмнөх тест, Ц. Туяа-ЭМГ-ын дарга, сайн засаглалын сургагч багш Сайн засаглал, үндсэн зарчмууд, Монгол хүний эрх үүрэг, Төрийн захиргаа удирдлагын хэлтэсийн дарга Б.Мандах Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцааны ур чадвар, Д.Баттайван Мэдээлэлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, төрийн байгууллагууд ямар мэдээллээ ил тод байлгах үүрэгтэй вэ?Иргэд ямар мэдээлэл авах эрхтэй вэ?Мэдээлэл хүсэгчийн эрх үүрэг, Дасгал ажил, П.Бат-Очир Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Ашиг сонирхлын хууль, н.Баттөмөр Худалдан авах ажиллагааны албаны дарга Худалдан авах ажиллагааны ил тод байдал, Г. Мөнхбат-Залуучуудын холбооны тэргүүн, Б.Даваацэрэн Нарийн бичгийн дарга Төрийн байгууллагын ил тод байдлын сайн жишээ-бусад аймаг, олон улсын, Д.Баттайван, Б.Мандах, Б.Даваацэрэн Хэлэлцүүлэг Төрийн мэдээлэлийн чанар, хүртээмжийг хэрхэн сайжруулах вэ?, Б.Даваацэрэн Сургалтын дараах тест авч сургалтыг явууллаа.</p> <p>Төрийн байгууллагын дарга удирдлагууд, мэдээлэл хариуцсан ажилчид идэвхтэй оролцон тодорхой саналууд гаргалаа. Байгууллага бүр өөрсдийн гэсэн веб сайттай болох. Мэдээллийг цахим хэлбэрээр иргэдэд хүргэх нь илүү үр дүнтэй тэдний цаг хугацааг хэмнэсэн зөв зүйл гэх мэт. Уг сургалтанд Аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргаар нэмэлт мэдээлэл хийлгэлээ.</p> <p>Орон нутгийн хэвлэл мэдээллийн “Зэргэлээт-Алтай” ТВ, Их “Алтайн мэдээ” сонингийн газруудыг урьж мэдээлэл бэлтгүүлээ. Мөн телевизийн хөтөлбөр, сониний дугааруудад мэдээлэл өглөө.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
2.10	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, Хандив авахтай холбогдсон хориглолт хязгаарлалтын талаар сумдад зөвлөмж хүргүүлэх	Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын удирдлагууд	Жилийн турш	<p>Тайшир сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор сум сургууль үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ой болохтой холбогдуулан айл өрхүүдээс хандив авахаар шийдвэрлэсэн тогтоолыг хүчингүй болгуулах талаар албан бичгийг хүргүүлж, уг тогтоолыг хүчингүй болгууллаа.</p> <p>аймгийн хэмжээнд тус онд олон сум сургууль үүсэн байгуулагдсаны ойн жил тохиж байгаатай холбогдуулан сумын ИТХ –ын дарга болон Засаг дарга нарт аливаа хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн</p>

				хэлтсээс 2014 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 5/202 дугаар албан бичгээр зөвлөмжийг хүргүүлэв. Холбогдох хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хориглолт хязгаарлалтыг сануулсан, хандив туслалцаа өгсөн иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, хөрөнгө мөнгийн судалгааг гаргуулж авах албан бичгийг тус тус хүргүүлж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
2.11	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байдал, Албан тушаалтанд давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгосон байдал	Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын удирдлагууд	Тухай бүр	Давхар ажил эрхлэж болох ажлын жагсаалтыг аймгийн Вэб сайтанд тавьж, Мөн зохион байгуулсан сургалтад хамрагдсан албан тушаалтнуудад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хориглолт хязгаарлалтын талаар 19 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн сургалтанд танилцуулж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
2.12	Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмын биелэлт	Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын удирдлагууд	Тухай бүр	Давхар ажил эрхлэж болох ажлын жагсаалт болон давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг аймгийн Вэб сайтанд тавьж, нийтийн албан тушаалтнуудыг мэдээллээр хангалаа. Хэрэгжилт 70 хувь
2.13	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах	Нутгийн захиргааны байгууллагууд Хууль зүйн хэлтэс, хяналт тавина.	Жилдээ	Авлигатай тэмцэх газраас 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/2453 дугаар албан бичгээр Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан тухай танилцуулгыг ирүүлсэний дагуу сумдад нутгийн ой тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор хандив туслалцаа өгсөн иргэн хуулийн этгээдээс хуулиар хориглосон хязгаарлалтыг зөрчихөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар хууль тогтоомжийг сануулсан албан бичгийг хууль зүйн хэлтсийн даргын 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 5/549 дүгээр албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
2.14	Хамтрагч байгууллагуудтай хийх аливаа гэрээнд ёс зүй, сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар тусгах, /ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллах г.м./	Хууль зүйн хэлтэс хяналт тавьж ажиллана.	Жилдээ	Алтайн Хүдэр ХХК-тай нийгмийн хариуцлагын гэрээг байгууллаа. Хэрэгжилт 90 хувь
2.15	Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна.	Төрийн байгууллагын удирдлагууд	11-12 дугаар сард	Авлигын эсрэг ОУ-ын өдрийг угтан 2013 оны 12 сарын 9-нд аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албатай хамтран Олон улсын Авлигын эсрэг өдрийг тохиолдуулан аймгийн төвийн ЕБС-ийн сурагчдын дунд “Авлига хүний эрхийг зөрчих хэрэгсэл болдог” гар зургийн уралдаан, “Шударга ёс-хүний эрх” Дэвжээ тэмцээнийг тус тус зохион байгууллаа. Гар зургийн уралдаанд 6 сургуулийн 23

				<p>сурагч бүтээлээрээ оролцсон зургуудаар Алтай чуулгад үзэсгэлэн гаргав. Уралдаанд 2-р сургуулийн сурагч Б. Хишигмаа шалгарч тэргүүн байр эзэллээ. Дэвжээ тэмцээнд 6 сургуулийн 48 сурагч мэдлэг ур чадвараа сорьж уралдлаа. Тэмцээнд оролцсон хүүхдүүд авлига, шударга бус нийгэм улс эх орны болон орон нутгийн хөгжлөөс хэрхэн хойш татаж байгаа тухай, авлигаас болж нийгэмд үүсч байгаа сөрөг үйл явдлууд, авлигатай хэн тэмцэж, хэн улам авлигыг дэвэргэж байгааг жүжиглэн үзүүллээ. Тэмцээний бичлэгийг бүрэн эхээр нь бичиж Миний нутаг ТВ-ээр цацлаа .</p> <p>“Хууль дүрэм бодит амьдрал-2” аяны хүрээнд “Мэдээлэлтэй иргэд оролцоотой” арга хэмжээг Баян-Уул, Шарга сумдад 2014 оны 05 сарын 20-ноос 05 сарын 22-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Уг арга хэмжээний үеэр сумын төвийн төрийн албан хаагчид болон иргэд нийтийг оролцуулан “Мэдээлэлтэй иргэд оролцоотой” сэдэвт сургалт хэлэлцүүлэг, дэвжээ тэмцээнийг зохион байгууллаа.</p> <p>Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд нээлттэй ил тод байдлыг хангахад төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Мэдээлэлтэй иргэд оролцоотой” сэдэвт хууль эрх зүйн уралдаант дэвжээ тэмцээнийг аймгийн төвийн төрийн албан хаагчдын дунд 2014 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Ардын дуу бүжгийн Алтай чуулгад зохион байгууллаа.</p> <p>Уг тэмцээнд 21 байгууллагын хамтарсан 5 баг оролцож, үйл ажиллагаандаа мөрдөгдөх хууль тогтоомжийн мэдлэгээрээ өрсөлдөж, Тээвэр, авто замын газар, Татварын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэдээлэл сүлжээ ТӨХК, Хөдөлмөрийн хэлтсийн хамтарсан “Жиргээ” баг тэргүүн байр эзэллээ.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
2.16	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл , хөтөлбөр, түүний хэрэгжилтийн байдлын мэдээллийг нээлттэй болгож, иргэд олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, аймгийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	ТЗУХ, ХЗХ	Тухай бүр	<p>Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн Амын Сан нь Монгол улсад 2012-2016 онд “Хүн ам ба хөгжил, хөндөрт суурилсан хүчирхийллийг бууруулах, залуусын хөгжлийг дэмжих” хөтөлбөр, Норвегийн тусламжийн байгууллагын “эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх-2” төсөл, Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-3 төсөл, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын аймаг дахь орон нутгийн хөгжил хөтөлбөр, Мерси Кор ОУБ-ын хэрэгжүүлж буй “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөө идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” төслүүдийн хэрэгжилтийн байдлыг аймгийн вэб сайтанд байрлуулж, аймаг орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд төслийн үр ашгийг</p>

				Алтайчууд хэрхэн хүртэх болон үр ашгийг нь мэдээлж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
2.17	Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж, төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийн нээлттэй байлгана. Мөн үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийн ил тод байлгана	ТЗУХ, ХШҮ тасаг, төрийн байгууллагууд	Жилийн турш	Аймгийн засаг даргын бүрэн эрхийн хүрээнд гаргаж буй шийдвэрийг ил тод нээлттэй байдлыг хангуулах үүднээс gov-altai.gov.mn вэб сайтад тогтмол тавьж, иргэд олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж хэвшлээ. Хэрэгжилт 100 хувь
2.18	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулж, иргэд олон нийт, сонирхогч бүлгийн санал солилцох боломжийг бүрдүүлж ажиллах.	Аймгийн ИТХ, түүний ажлын алба, ТЗУХ, ХБХ, НХХ, СТСХ, журмын төслийг боловсруулсан холбогдох төрийн байгууллагууд	Жилийн турш	Аймгийн Засаг даргын 2014-2016 оны үйл ажиллагааны "Бидний-Алтай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулж, бүх сумдаар төлөвлөгөөний төслийг иргэдэд сурталчилан иргэдээс саналыг авч иргэдийн оролцоонд тулгуурлан боловсрууллаа. Аймгийн төвд таксины үйлчилгээний талаар үйлчлүүлэгч 540 иргэнээс 06 дугаар сард санал авч нэгтгэхэд аймгийн төвд үйлчилж буй таксины үйлчилгээний талаар үнэлгээ өгнө үү гэсэн асуултад 105 иргэн буюу 19,4 хувь хангалттай, 232 иргэн буюу 43,0 хувь дунд, 203 иргэн буюу 37,6 хангалтгүй гэсэн үнэлгээг тус тус өглөө. Уг журмын төслийг боловсруулах шатандаа явж байна. Хэрэгжилт 100 хувь
2.19	Тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрлийг олгох журам, холбогдох бичиг баримтын жагсаалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэнэ	Холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтан, байгууллагууд	Жилийн турш	Аймгийн Засаг даргын зүгээс олгож буй архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 33 дугаар тогтоолоор батлууллаа. Уг журмыг аймгийн вэб сайтанд тавьж, тусгай зөвшөөрөл хүсэх иргэдийн тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримттай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа. Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн бүртгэлийг цахим хуудсанд тухай бүр байршуулсан. Хэрэгжилт 100 хувь
2.20	Нийтийн албан хаагчдын дунд авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна. Үүнд: Төсвийн шууд захирагч болон нийтийн албанд шинээр томилогдож буй албан хаагч нарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар болон Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар сургалтыг зохион байгуулах.	Хууль зүйн хэлтэс бусад байгууллагуудтай хамтрах	2-оос доошгүй удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр баталсан сургалт хөтөлбөрийн дагуу нийт сумдын ЗДТГ-ын дарга нар, болон дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд, багийн дарга нарт, 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр орон нутгийн удирдлагууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан цахим зөвлөлдөх уулзалт, 2014 оны 05 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Онцгой байдлын хэлтсийн албан хаагч нарт 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдөр

				<p>“Орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын бүсчилсэн сургалт” –д оролцогч Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар сургалт семинарыг өглөө.</p> <p>Мөн Авлигатай тэмцэх газраас “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтныг чадавхижуулах” сэдэвт бүсчилсэн сургалтад Ховд аймагт 09 дүгээр сарын 29-ны өдөр 10 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулагдлаа.</p> <p>Уг сургалтад сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар болон агентлагийн эрх бүхий албан тушаалтан нийт 46 албан хаагчийг хамруулан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, гарч буй нийтлэг зөрчил дутагдлын талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтанд хамрагдлаа.</p> <p>Уг сургалт семинаруудад нийт 300 албан тушаалтнууд хамрагдаж, Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар мэдлэг мэдээлэлтэй боллоо.</p> <p>Аймгийн авлигын эсрэг төлөвлөгөөний дагуу сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд өөрсдийн байгууллага салбарын онцлогт тохируулан төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу байгууллага бүр ажиллагсаддаа Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилж ажиллалаа.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
Гурав. Байгууллагын төсвийг төлөвлөгдсөн зардалд үр ашигтай зарцуулах				
3.21	Байгууллагын төсвийг төлөвлөгдсөн зардалд үр ашигтай зарцуулна.	Санхүү, төрийн сангийн хэлтэс, төрийн байгууллагууд	Төсвийн зүйл, зардлын тоогоор	Төсөвт байгууллагуудын 2014 оны батлагдсан төсөв, хуваарийн дагуу санхүүжилтийг олгож, төсөв санхүүгийн ил тод байдлын самбарт байршуулж хэвшсэн. Сангийн сайдын 2014 оны 01 сарын 10 –ны 05 дугаар тушаалаар батлагдсан эдийн засгийн ангилалын дагуу төсөвт байгууллагын гүйлгээг хянаж төлбөр тооцоог гүйцэтгэж, төсөвт байгууллагууд аймгийн Засаг даргын А/62 захирамжийн дагуу сар бүрийн эхний долоо хоногийн

				бямба гаригт төсвийн зарцуулалтын талаар иргэдэд мэдээлж байна. Санхүү, төрийн сангийн хэлтсээс Засгийн газрын 17-р тогтоолын хэрэгжилтийг 2014 оны 06 сарын 03-06 хооронд аймгийн төсвийн 60 байгууллагад шалгаж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
3.22	Төсөв, санхүүгийн тайланг сар, улирал жилээр хугацаанд нь гаргаж холбогдох дээд байгууллагад тайлагнах, цахим хуудсанд байршуулах.	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хуулинд заасан хугацаанд	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2014 оны хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд гаргаж аудитын байгууллагаар баталгаажуулан, Сангийн яаманд нэгтгүүлсэн бөгөөд аймгийн gov-i-altai.gov.mn вэб сайтад байршууллаа. Хэрэгжилт 100 хувь
3.23	2014 оны төсвийг байгууллагын цахим хуудаст байршуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн байгууллагын удирдлагууд	Хуулинд заасан хугацаанд	Төсвийн тодотгол хийсэн тухай бүр аймгийн Засаг даргаар сар улирлын хуваарь батлуулж, аймгийн вэб сайт болон төсвийн ил тод байдлын самбарт тогтмол мэдээллэж байна. Хэрэгжилт-100 хувь
3.24	2013 оны төсвийн гүйцэтгэлийг ил, тод нээлттэй болгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн байгууллагын удирдлагууд	Хуулинд заасан хугацаанд	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тайланг аймгийн gov-i-altai.gov.mn вэб сайтад, аймгийн “Төсөв санхүүгийн ил тод байдлын самбарт байршуулсан. Мөн 2013 оны төсвийн гүйцэтгэлийг аймгийн ИТХ –н 2014 оны 05 сарын 31-ны хуралдаан оруулан хэлэлцүүлж, 37 дугаар тогтоолоор батлууллаа. Хэрэгжилт 100 хувь
3.25	2015 оны төсвийн төслийг ил тод, нээлттэй болгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн байгууллагын удирдлагууд	Хуулинд заасан хугацаанд	2015 оны төсвийн төслийг Сангийн яаманд байгууллага бүрээр хянуулж, хяналтын хуудсыг төсвийн ил тод байдлын самбарт байршуулсан. Хэрэгжилт- 70 хувь
3.26	2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь ил тод, нээлттэй болгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн байгууллагын удирдлагууд	Хуулинд заасан хугацаанд	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Санхүү төсвийн ил тод байдлын самбар болон аймгийн вэб сайтад байршуулж иргэд олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүллээ. Хэрэгжилт 100 хувь
3.27	2014 оны төсөвт нэмэлт орсон талаарх мэдээллийг ил, тод нээлттэй болгох /ороогүй бол энэ талаар мэдээлэх/	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн байгууллагын удирдлагууд	Хуулинд заасан хугацаанд	Тус 2014 онд орон нутгийн төсөвт 2014 оны 03 дугаар сарын 16, 04 дүгээр сарын 30, 07 дугаар сарын 22-нд тодотгол хийсэн. Цаг тухай бүр нь аймгийн веб сайт болон төсвийн ил тод байдлын самбарт тогтмол мэдээллэж байна. Хэрэгжилт 100 хувь
3.28	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн талаарх жагсаалт гаргах, ил тод, нээлттэй болгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн байгууллагын удирдлагууд	Хуулинд заасан хугацаанд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан тушаалтнуудын ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсэн амаржсаны тэтгэмж зэрэг нийт 11 иргэнд 25.330.741 төгрөгийг нийгмийн даатгалын сангаас олгожээ. Хэрэгжилт 100 хувь

Дөрөв. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах				
4.29	Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллээр хугацаанд нь мэдээлсэн байх -Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр /төсвийн хөрөнгө оруулалтын задаргаа/ мэдээлсэн байх	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Жилийн турш	2014 онд Худалдан авах ажиллагааг нийт 115 ажлыг төлөвлөж, зохион байгуулж, Монголын үнэн, Зууны мэдээ зэрэг өдөр тутмын сонин, <a href="http://www.govi-altai.gov.mn">www.govi-altai.gov.mn</a> , <a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a> , <a href="http://www.meps.gov.mn">www.meps.gov.mn</a> , Вэб сайтад төлөвлөгөө, урилга, үр дүн, явцыг тайлагнаж байна. Хэрэгжилт 100 хувь
4.30	Үнэлгээний хороонд сонирхлын зөрчилгүй хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байх	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Жилийн турш	Тус онд худалдан авах ажиллагааг нийт 115 ажилд зохион байгуулж үнэлгээний хорооны гишүүдийн 40 хүртэл хувьд иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувь
4.31	Бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг бий болгож, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж хэвших	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	Тус онд Худалдан авах ажиллагааны албанаас зохион байгуулсан нийт ажилд Бараа ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээд бүртгэлд байхгүй. Хэрэгжилт 100 хувь
4.32	Худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр ашигтай байх үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор 3 суманд хяналт шалгалтын ажил зохион байгуулах	Худалдан авах ажиллагааны алба, Хууль зүйн хэлтэс, төрийн бус байгууллагууд	08 сард	Цээл, Хөхморьт сумдад худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөө, зохион байгуулалт, тайлан мэдээ гаргах, үнэлгээний хорооны үйл ажиллагаа зэрэг ажлуудтай танилцаж удирлага зөвлөмж өгч ажилласан. 9 сард Худалдан авах ажиллагааны газрын ажлын хэсгийн гишүүдтэй Есөнбулаг сумын ЗДТГ-ын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ажилд хяналт шалгалт хийж гарсан алдаа дутагдлыг засаж, санал зөвлөмжийг хэлэлцсэн. Хэрэгжилт 100 хувь
4.33	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод болгох	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	Бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчид тавих шалгуур үзүүлэлтийг тендерийн жишиг баримт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг удирдлага болгож нээлттэй ил тод зохион байгуулж байна. Хэрэгжилт 90 хувь
4.34	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг нээлттэй болгох /шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэлийг тодорхой танилцуулах/	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	Тухайн бараа ажил үйлчилгээг худалдан авахад оролцсон иргэн хуулийн этгээдийн шалгарсан, шалгараагүй үндэслэлийг <a href="http://www.govi-altai.gov.mn">www.govi-altai.gov.mn</a> вэб хуудсан тавьж байна. Хэрэгжилт 90 хувь
4.35	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	Тендер шалгаруулалттай холбоотой зөрчил гараагүй. Хэрэгжилт 90 хувь

4.36	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг ил тод, нээлттэй болгох	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	Mercury-Corps олон улсын байгууллага нь “Биндэр атас богд” ТББ, “Үнэлэмж” ТББ, “Алтайн Швейцар сан” төрийн бус байгууллагуудаар төлөөлүүлэн Төрийн худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт тогтолцоог бэхжүүлэх төслийг хэрэгжүүлж Баян-Уул, Есөнбулаг сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт, явцын гүйцэтгэлд хяналт тавиж ажиллах төслийг хэрэгжүүлж, төрийн бус байгууллагуудын тайлан мэдээг нэгтгэж авч цаашид авах арга хэмжээндээ төлөвлөн ажиллаж байна. Хэрэгжилт 90 хувь
Тав.Байгууллагын онцлогт тохирсон ёс зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэх				
5.37	Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж, тэдгээрээр гарын үсэг зуруулсан байх	Байгууллагын удирдлагууд	Жилийн турш	Аймгийн Засаг даргын орлогчоор батлуулан хүргүүлж, батлагдсаны хүрээнд <b>“МЭДЭЭЛЭЛТЭЙ ИРГЭД ОРОЛЦООТОЙ”</b> сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар Төрийн албан хаагчдын ёс зүй, ёс зүйн дүрэм, харилцааны ур чадварын талаар сургалт хийлээ. Хэрэгжилт 70 хувь
5.38	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөл байгуулж, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөлийн ажиллах журам, 2014 оны ажлын төлөвлөгөөг баталсан байх	Нутгийн захиргааны байгууллагууд. Хяналт тавих- ТЗУХ	2 дугаар сарын 25-ны дотор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/37 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хороог шинэчлэн байгууллаа. Хэрэгжилт 70 хувь
5.39	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгасан байх	Нутгийн захиргааны байгууллагууд. Хяналт тавих- ТЗУХ	Жилийн турш	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс хяналт тавьж, зөрчлийн талаарх тайлан мэдээг хагас бүтэн жилээр нэгтгэн авч дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар ёс зүйн дүрмийг зөрчсөн 8 албан тушаалтан мэдээллийг нэгтгэн авч тайлагналаа. Аймгийн Засаг даргын 2014 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Б/120 дугаар захирамжаар Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын дагуу гаргасан албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллагаагүй төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч нарт сахилгын шийтгэл ногдууллаа. Хэрэгжилт 90 хувь
5.40	Ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтийг хариуцлага хүлээлгэх, урамшуулахад харгалзан үзсэн байх	Нутгийн захиргааны байгууллагууд. Хяналт тавих- ТЗУХ	Жилийн турш	Төрийн албаны зөвлөлийн төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн , мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмын төсөлд аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга нар, албан хаагчдыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргийг нэг шалгуур үзүүлэлт болгох талаар гарсан саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ. Хэрэгжилт 50 хувь
5.41	Ажилтан албан хаагчдын үйл ажиллагаанд оршиж буй нэн даруй засах зүйлийн жагсаалт, зөвлөмжийг гаргаж хүргүүлэх	Ажлын хэсэг, төслийн баг	3-р сард	-

Зургаа. Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах				
6.42	Тухайн жилд явуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний үр дүнг олон нийтэд цахим хуудас, хэвлэл мэдээллийн боломжит хэлбэрүүдээр мэдээлэх. Хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана. Хяналт шалгалтын дагуу иргэд, аж ахуй нэгж эрхлэгчид зөвлөмж, зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулах	АЗДТГ, Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, цагдаагийн хэлтэс, стандартчилал хэмжил зүйн хэлтэс, татварын хэлтэс болон бусад холбогдох албан байгууллагууд	Жилийн турш	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, аймгийн ИТХТ болон Засаг даргын захирамж шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 09 дүгээр сарын 15-26-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын орлогоор ахлуулсан аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналт газар, Цагдаагийн хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Татварын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Есөнбулаг сумын ЗДТГазартай хамтран тусгай зөвшөөрөлтэйгээр архи согтууруулах ундаа худалддаг түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион явуулаа. Удирдамжийн дагуу Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Галын аюулгүй байдлын тухай, Хүнсний худалдаа үйлчилгээний газруудад “Худалдааны газар түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5021-2007, Баар, Зоогийн газруудад “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага” MNS 4946-2005 стандартуудын мөрдөлтийг хянах, Хүнсний тухай хууль болон үйлчилгээний орчин нөхцөл стандартын шаардлага аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн баталсан шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлын хүрээнд нийт архи согтууруулах ундаа худалддаг дэлгүүрийн 53 аж ахуйн нэгж ,үйлчлэх үйл ажиллагаа явуулж байгаа 23 /ресторан, кафе, баар/ 76 цэг хамрагдлаа. Уг шалгалтын дүнг 10 дугаар сарын 30-ны өдөр шалтгалтад хамрагдсан хуулийн этгээдүүдийн төлөөллийг байлцуулан шалгалтын дүнг танилцуулж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
Долоо.Хүний нөөцийн ил тод байдлыг хангах				
7.43	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах	Нутгийн захиргааны байгууллагууд, ТЗУХ	Тухай бүр	Тайлант онд аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг нэгтгэн гаргасан бөгөөд төрийн албаны мэргэшлийн шалгалт , удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулан явуулаагүй болно. Төрийн албаны салбар зөвлөл нь удирдах, гүйцэтгэх ажилтны сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны <a href="http://www.csc.gov.mn">www.csc.gov.mn</a> сайтад байршуулан орон нутгийн телевизүүд болон <a href="http://www.govi-altai.mn">www.govi-altai.mn</a> цахим хаяг, аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт сонгон шалгаруулалтын зарыг байршуулан иргэд олон нийтэд мэдээлж ажиллалаа. Хэрэгжилт 90 хувь

7.44	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас, мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Нутгийн захиргааны байгууллагууд, ТЗУХ	Тухай бүр	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйг хянан шийдвэрлэх журмыг аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад танилцуулж, мэдээллийн самбарт 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байршуулж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
7.45	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг ойлгомжтой байдлаар байршуулах	Нутгийн захиргааны байгууллагууд, ТЗУХ	Тухай бүр	Хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг боловсруулахаар төлөвлөөд байна. Хэрэгжилт 10 хувь
7.46	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	Нутгийн захиргааны байгууллагууд, ТЗУХ	Тухай бүр	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, төрийн бодлого, шийдвэрт иргэдийн санал хүсэлтийг тусгах зорилгоор эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилогдох ажлын хэсэгт тухайн салбартаа мэргэшсэн, туршлагатай иргэдийн төлөөллийг оролцуулах, удирдах, гүйцэтгэх албан тушаалтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулж сонирхсон иргэд шалгалтын үйл явцыг хянах боломжоор хангах зорилгоор камераар иргэдэд хүргэх зэрэг ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Хэрэгжилт 30 хувь
7.48	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Нутгийн захиргааны байгууллагууд, ТЗУХ	Тухай бүр	Албан хаагчдын үйл ажиллагааг Бүтэн жилээр үнэлж дүгнэхдээ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу үр дүнгийн гэрээ байгуулан үнэлж дүгнэж байна. Төрийн албаны зөвлөлийн төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмын төсөлд аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга нар, албан хаагчдыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ. Хэрэгжилт 50 хувь

Төлөвлөгөөний гүйцэтгэл: Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлийг тооцоход 100 хувьтай -29, 90 хувьтай -9, 70 хувьтай -5, 50 хувьтай -2, 30 хувьтай -1, 10 хувьтай -1 нийт ерөнхий үнэлгээ 87,5 хувьтай байна.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН П.БАТ-ОЧИР  
ХЯНАСАН: ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.МАРГАД-ЭРДЭНЭ